

АМЬДРАНГАА СУРЧ, СУРАНГАА АМЬДРАХ (ИНФОРМАЛ) ДАВАМГАЙЛСАН МОНГОЛ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ТУХАЙД

Ч.Пүрэвдорж, Sc.D, профессор, БоСС

Хураангуй: Монголын боловсролын уламжлалт тогтолцоо, түүний үечлэл, хөгжлийн загвар, зарим онцлог болон давамгайл шинжтэй информал хэлбэрийг тодорхой баримт жишээн дээр авч үзсэн болно.

Түлхүүр үг: Амьдрангаа сурах, сурангаа амьдрах, боловсролын хөгжлийн үечлэл, загвар, амьтнаас сурах, Алан гоо эхийн хичээл, амьдралын үнэн, сүегэр үг, суяах, тэжээхүй, монгол боловсролын тогтолцоо, сурахуйн зай тойрог

Мэдлэг, чадвар улиран уламжлах, дахин шинээр бий болох нь боловсрол хэмээгч оршин буйн утга учир юм. Ийм явдал аль ч нийгэм, аль ч цаг үед байсаар ахуй нь хүмүүний язгуур чанараас үүдэлтэй, зайлшгүй шинж бүхий ажгуу. Монголчуудын ялалт амжилт, хөгжил дэвшил оргүйгээс гэнэт бий болсонгүй, эртний Хүннү, түүнээс ч өмнө үеэс өртөөлөн улбаалжээ. Дундад эртний үе гэхэд Есүхэй баатрын хүү Тэмүжин Монгол улсаа байгуулан мандуулснаар “хөнөөлдөн тэмцэлдсэн” олон овог аймаг оюун санааны хувьд нэгдэн нийлж, чанарын шинэ дэвшилд хүрсэн байх ажаамуй. Чингис хааны бодлого суртлыг Өгөдэй, Гүюг, Мөнх, Хубилай тэргүүтэн Их хаад залгамжлан хөгжүүлжээ. Шинэхэн үед тохиолдсон үндэсний тусгаар тогтнол, ардын хувьсгал, ардчилсан хувьсгал тэргүүтэн түүхэн их ялалт амжилтыг байгуулахад шалмаг гавшгай морин цэрэг, арыг нь даасан нүүдлийн аж ахуй, эзлэгдсэн түмнийг бишрүүлэн дагуулах хошуучлагчид их үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой боловч оюун сэтгэхүйн хүч, чадваржсан мэдлэг, түүний далд хэлбэрийг дутуу үнэлж боломгүй. Тэр бүх ялалт амжилтын цаана боловсролын өвөрмөц тогтолцоо оршин байсан нь лавтай билээ.

Орчин цагт боловсролыг, хэн бүхний мэдэхээр, бүтцийн хувьд албан боловсрол (Formal Education), албан бус боловсрол (Nonformal Education), амьдарч, аж төрөх явцад олох информал боловсрол¹ (Informal Education) гэж

ангилан үзнэ. Ийм байр сууринаас нэн шинэхэн үеийн боловсролыг хэрхэн үзэх нь ойлгомжтой хэрэг. Харин түүнээс өмнөх үед тухайлбал, Чингис хааны үе хийгээд ер монголын хаад, мэргэд, ард иргэд цөм мэдлэг боловсролыг хэрхэн олов гэдэг асуулт хэн бүхний сонирхон сонжих зүйл лав мөн биз. Үүнд холбогдуулан, монголын сургалт боловсролын тогтолцооны талаар цөөн санаа сэдэхийг оролдов. Юуны өмнө, эрт үеийн Монгол улсад боловсролын тогтолцоо дахь дээр өгүүлсэн гурван бүрэлдүүлбэрээс информал гэгдэх тэрхүү хэсэг илүү давамгайл байсан гэдгийг хэлэх хэрэгтэй болов уу. Энэ бол монгол нүүдэлчдийн боловсролын тогтолцооны онцлог байв. Эхлээд Монгол улсынхаа боловсролын хөгжлийн үечлэлд анхаарал хандуулсу. Түүхэн хөгжлийн үүднээс судалгаа хийхэд юуны өмнө үечлэлийг чухалчлана. Монгол улсын боловсролын тогтолцооны хөгжлийг судлаачид янз бүр үечлэх боловч голцуу 1921 оноос хойш үеийг хамруулж, хувьсгалын өмнөх үеийн боловсролын систем (1911-1921), хувьсгалын ардчилсан шатны үе (1921-1940), Ардын хувьсгалын социалист шатны үе (1940-1970) гэх мэт боловсролын хөгжлийн түүхэн үеийг тодорхойлсон байдаг². Харин Ш.Шагдар гуай монголын боловсролын хөгжлийн түүхийг хоёр хэсэг, найман үе болгон хуваасан байна³.

Боловсролын түүхэн хөгжлийг үечлэхдээ ямар нийгэм, ямар суртахуун буйгаас үл шалтгаалан, уг тогтолцооны өөрийнх нь технологи, жам ёсны шинж чанарт тулгуурлах нь илүү нийтлэг байж мэдэх юм. Энэ нь боловсролын тогтолцооны бүрэлдүүлбэрийн хөгжлийн явцыг харгалзана гэсэн үг. Үүнийг бодолцон, Монгол улсын боловсролын тогтолцооны хөгжлийг⁴:

2 Даваасүрэн Б. “БНМАУ-ын ерөнхий боловсрол түүний хөгжлийн хэтийн төлөв”. -Уб., 1979.

Жамъянжав Т. “Ардын боловсролын системийг боловсронгуй болгох талаар МАХН-аас явуулсан бодлого”. - Уб., 1987

Машлай Т. “Монголын ерөнхий боловсролын хөгжилт”. - Уб., 1958. Шагдарсүрэн Л. “БНМАУ-ын ерөнхий боловсрол, хөдөлмөр политехник сургуулийн үүсэл хөгжилт”. - Уб., 1976.

3 Шагдар Ш. “Монгол улсын боловсролын түүхэн товчоон”. - Уб., 2000, 10 дахь тал.

4 Пүрэвдорж Ч. “Багшлахуйн менежмент”, Уб., 2011, 134 дэх тал.

1 Үүнийг зарим судлаач (тухайлбал, Х.Дүгэр “Монгол улсад албан бус боловсролын тогтолцоо бүрэлдүүлэн төлөвшүүлэх онол, аргазүйн асуудалд”, Уб., 2001, 34 дэх тал) амьдрал орчноос олох боловсрол гэсэн байдаг. Харин энэ удаад “амьдарч, аж төрөх явцад олох боловсрол” гэж агуулгаар нь нэрлэсний зэрэгцээ бас галиглан нэрлэв.

1. Амьдарч аж төрөх явцад олох информал боловсрол давамгайлсан үе (нэн эртнээс XX зууны 20 –иод он)

2. Албан бус боловсрол давамгайлсан үе (XX зууны 20-иод оноос 50 -иод оны дунд үе)

3. Албан боловсрол давамгайлсан үе (XX зууны 50-иод оны дунд үеэс 90 –ээд оны дунд үе)

4. Боловсролын тогтолцоо бүрэн утгаар бүрдэх эхэн үе (XX зууны 90–ээд оны дунд үеэс хойш) хэмээн үечилж болмоор байна.

Боловсролыг тогтолцооных нь хувьд үечлэх явдал аливаа нийгэмд боловсрол юуны тулд оршин хөгжих вэ гэдэгт холбогдох түүний дотоод хүчин зүйлд үндэслэх бол, түүхэн дарааллыг баримталсан үечлэл үйл явц, нийгмийн орчин мэт боловсрол юунаас шалтгаалан хөгжих вэ гэсэн гадаад хүчин зүйлд тулгуурласан зарчмын ялгаатай юм. Боловсролыг дотоод хүчин зүйлд нь тулгуурлан үечилбэл, манай улсын хувьд жам ёсны, үзэл сурталжсан, прагматик гэх хөгжлийн гурван янз загвар байсан⁵ гэж хэлж болохоор байна.

Монгол нүүдэл бол зөвхөн орон зайн шилжилт эсвэл тэнүүлч амьдралаас ялгаатай бөгөөд хүмүүний байгаль орчинд дасан зохицох, амьдарч аж төрөх цогц үйл явцын нэгэн хэлбэр ба түүний чухал хэсэг нь сургалт, боловсрол лавтай мөн юм. Бусдын нэгэн адил монголчууд ч гэсэн амьдралынхаа орчноос мэдлэгийн үлэмж хэсгийг олно. Мал болбоос амьтан мөний хувьд, хүмүүн нь түүнээс суралцах боломжоор газар тариаланг бодвол илүү юм. Монгол нүүдэлчний хүүхэд хар багаас мал сүргийг ажиглан, түүнтэй хутгалдсаны хүчинд ертөнцийг үзэх улам хөдөлгөөнт, амьдлаг маягийн үзэл төлөвшихөд дөхөмтэй байна. Чухамдаа, нүүдэлчин монголчуудын амьдралд байгалийн хатуу ширүүн байдал ул мөрийг үлдээх боловч мал сүрэг нь тэдний амьдрал, сэтгэхүйд түүнээс ч дутуугүй хүч нөлөөг үзүүлнэ. Яагаад гэвэл, мал сүрэг бол олон төрлийн амьд амьтан. Тэнд өсөж үржих, үхэж мөхөх, өвдөж эдгэрэх нь ертөнцийн жам ёсны дагуу явагдсаар байдаг. Сайтар ажиглахуйд, сайн, муу ааш авир, амьдрахын төлөөх тэмцэл, уй гашуу, баяр хөөрийг ч тэндээс харж болно. Мал маллах нь тариа ногоо ургуулахтай адилгүй. Тариачин хүн улирлын чанартай, хэсэг газарт хадаастай мэт байх бол малчин хүн өргөн уудам орон зайд үлэмж чөлөөтэй хөлхөн явахын хамт үйл хэрэг нь өдөр шөнө, өвөл

зун ялгаагүй тасралтгүй үргэлжилнэ. Нөгөө талаар, зохиогч “Чоно менежмент” гэх сэдвийг хөндөж, монгол нүүдэлчдийн хувьд *амьтнаас сурах* хэмээсэн нэгэн зүйл үйл буйг тэмдэглэж байсан билээ⁶. Арслангийн нэг, цахлайн нэг, тахианы дөрөв, хэрээний тав, нохойны зургаа, илжигний гурав, нийт хорин зүйл суртал сургаалыг эдгээр адгуус амьтдаас авч суралцваас хүн аль ч үеийн хүмүүн ёсонд тэгшрэн төлөвшихийг Буддын утга зохиолын их цоморлог Данжуурын 211 дүгээр ботид өгүүлсэн байх аж. Энэ нь амьтнаас сурахуй аль ч цаг үед байж болохыг харуулахын зэрэгцээ зөвхөн мал маллахад ч бус бас анчин гөрөөчний амьдрал ахуйд ч ажиглагднам. Малчин малынхаа ая зан, амьдрал үйлийг хараад ертөнцийн олон янз жам ёсыг ухааран мэднэ. Нүүдэлч малчид сурсаар, аж төрсөөр орчлонг туулах хувь зохиолтой хүмүүс гэж өөрсдийг боддог онцлогтой. Бидний санал болгосон боловсролын хөгжлийн үечлэл, загвараас харахад манай эртний үеийн боловсрол сургалтад амьдарч аж төрөх явцдаа олох информал хэсэг илт давамгайлж байсан нь тодорхой юм. Одоо монгол боловсролын өвөөс энэ тухай бага сага тодруулахыг хичээсү.

Эх хүнийг шонгоос бөхлөн хүлчихсэн гэх маш бүдүүлэг жишээ татъя. Тэгвэл түүнд өвдөлт хэрхэн мэдрэгдэх вэ? Бие эрхтэн өвдөх нь мэдээжийн зүйл боловч харин ард үлдсэн хүүгээ гэх эхийн сэтгэл өвдөх нь далд бас юу юунаас хурц байж болно. “Тийм учраас л хүн төрөлхтний сайн сайхан байдлын үүднээс авч үзэх юм бол шинжлэх ухаан, шашин хоёр хоорондоо нягт холбоотой”⁷ гэсэн XIV Далай ламын үгийг энд ишилмээр санагдана. Учир нь орчин цагийн анагаах ухаан биеийн өвчнийг илааршуулах нь маргаангүй боловч сэтгэлийнхийг дөнгөх бил үү? Энэ бол яах аргагүй асуулт юм. Үүнээс болж үзэгдэх ба үл үзэгдэх ертөнцийг сайтар судлахын тулд арга буюу хүн төрөлхтний соёлын хоёр чухал салбар болсон шинжлэх ухаан ба шашныг зэрэгцүүлэн үзэх хэрэгтэй болдог байна. Түүн лүгээ адил мөн л хүн төрөлхтний амьдралын хоёр том хэлбэр болсон нүүдэл ба суурин иргэшлийн амьдралын учир шалтгааныг эрх биш зэрэгцүүлэн үзэхээс өөр аргагүй болно. Ийм байр сууринаас, энэ удаад монгол нүүдэлчдийн боловсролын өв уламжлалд холбогдох зарим цөөн санааг хөндөж байгаа билээ.

5 Пүрэвдорж Ч. “Боловсролын хөгжлийн загвар, үечлэлийг тогтолцооны онолын үүднээс шинжлэх нэгэн боломж” *Лавай МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, №4, 2009, 21-27 дахь тал.

6 Пүрэвдорж Ч. “*Чингис хааны удирдахуй дагуулихуй (Чоно менежмент)*” Уб., 2013.

7 Дээрхийн гэгээнтэн XIV далай лам Данзанжамц “Эгэл атом дахь орчлон ертөнц” (Манай дэлхийн төлөө шинжлэх ухаан ба шашин ажиллах нь) Уб., 2013, 9 дэх тал.

Эцэг эх, ах дүүс, анд нөхөд, айл саахалт, ер хавь ойр хүмүүс зэрэгцэн амьдарч, хамтран аж төрөх зуур харах, сонсох, ярих, хүртэх маягаар асуулт тавих, ажиглах, даган дууриах, мэтгэлцэх, зөвлөлдөх, заалгах, эргэцүүлэх зэрэг хүмүүн бүрд тэнгэрээс заяасан боломжийг ашиглан, тодорхой нэгэн үйлийг үйлдэх ялдамд мэдлэг, ур чадвар олж, түүнээ хуримтлуулах зорилго чиглэлтэй үйл явцыг онолын хувьд амьдарч аж төрөх явцад олох информал боловсрол хэмээн ойлгож болно. Информал боловсрол нь өнөөгийн анги танхимын сургалтаас(албанба албанбус боловсролын)үлэмж ялгаатай төдийгүй, хүмүүний зөнгөөр аандаа сурахаас ч ангид ондоо юм. Хэдийгээр багш, шавь хэмээх болзол үгүй, хатуу тохироо хийгдэхгүй ч, сургагч хийгээд суралцагч хоёул байж, тэдний хэн хэн нь тодорхой зүйл заах, заалгах болон сурах, сургах зорилт тавигдана. Информал боловсролд урьдаас төлөвлөсөн хичээл гэх зүйл байхгүй, тухайн үед үүссэн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх маягаар тодорхой товлосон цаг хугацаа, орон байр, хэрэглэгдэхүүн, нөхцөл болзолгүйгээр явдаг сургалтын үйл явцыг боловсролын эл хэсэгт хамруулж байна. Жишээлбэл, малчин хүүхэд адуу малыг унаж эдлэх явцад эмээл хазаар, чөдөр ногт хэрэглэх, мал амьтныг арчилж хамгаалах, ааш авирыг номхотгох үй олон мэдэхгүй, чадахгүйд тулж болно. Тэр даруйд, бусдын дэмгүй мэдээд авчих хялбар зүйлийн сацуу мартан санан, алдан онон, ахин дахин оролдсоор сурдаг зүйл ч бишгүй олон. Монгол нүүдэлчний амьдралд хөл тавьж буй хүүхэд багачууд тавигдах асуулт бүрийн учир начрыг нэгэн хэв загвараар олох бололцоогүй, түүнийг шийдэх арга нь стандарт бус, тэр бүү хэл, шугаман бус шинж чанартай ажээ. Малчны ажил амьдрал өнгөц харахад нэгэн зүйлийг давтан хийх мэт боловч чухамдаа өөр өөр нөхцөл байдалд, өөр өөр аргаар хийгдэх тул арга барилаа ямагт шинэчлэхийг шаардах ба тэр нь сургалтын шинэ шинэ хэрэгцээг үүсгэсээр байх онцлог бүхий ажгуу. Жишээлбэл, ямаа маллагааны хувьд сурсныг тэмээ хариулахад хэрэглэж болдоггүй онцлогтой билээ.

Монгол нүүдэлчин бол зүгээр л амьдраад байдаггүй, харин түүнд суралцаж байдаг. Учир нь байгалиас заяасан угийн сониуч чанараар хүний оюун ухаан ямагт элдэв асуулт тавьсаар байх бөгөөд энэ нь түүний информал аргаар суралцах эх үндэс болдог. Монгол нүүдэлчний информал сургалтын мөн чанарт анхаарал хандуулбал дор дурдсан тогтвортой хандлага ажиглагдана. Тэд өөрсдийн амьдралд тохиолдсон материаллаг ертөнцийн юмс үзэгдлийг эхлээд ажиглах, дараа нь

эргэцүүлэн бодож ямар нэг дүгнэлт, гаргалга олж, түүнээ амьдралд ахин дахин туршин үзэж үр дүнг өмнөхтэй мөн бусдынхтай харьцуулах зэргээр итгэл үнэмшлийг олох ба тэр нь мэдлэгийнх нь нэг хэсэг болж улмаар цааш цаашид чадварждаг байна. Энэ бол нүүдэлчдийн зөвхөн информал сургалтад холбогдсон хандлага бөгөөд ерөөс шинэ мэдлэг бүтээхийн тухайд бол бас үүнээс өөр юм. Манай нүүдэлчид амьдралын үзэгдэл дэх эмпирийн ажиглалтад тулгуурлах боловч түүнээс оюун дүгнэлт хийх улмаар байгаль, хүний сэтгэхүйн хүрээний хувьд зарим тохиолдолд эмпирийн ажиглалтыг алгасаж цэвэр субъектив хүрээнд бясалгалын шинжтэй туршилтууд хийж, цоо шинэ мэдлэг бүтээх явдал бий юм. Аль ч тохиолдол нь бодит ахуйд эмпирийн байдлаар хандаж, эмпирийн туршилттай сөргөлдөж байгаа, уламжлалт байсан ч хамаагүй мэдлэгийг хүлээн зөвшөөрдөггүй нь монгол нүүдэлчдийн сэтгэлгээний нэгэн онцлог гэлтэй. Тийм ч учраас зохиогчийн хувьд *амьдралын үнэн* гэдгийг цохон хэлүүштэй санагдана. Дээр хэлсэнчлэн малчин хүн үнэнд хүрэхийн тулд шүүмжлэлт дүгнэлтээр дамжин очдог бөгөөд тэдний хувьд үнэн нь өөрсдийнх нь амьдрал юм. Тийм учраас тэдний үнэн нь өөрсдийнх нь амьдралд туршигддаг учраас энгийн үнэмшилтэй байх ажгуу.

Монгол нүүдэлчний сургалт боловсролын өв, түүний мөн чанарыг сайтар ухахын тулд хөвүүдээ сургасан Алан гоо⁸ эхийн нэгэн удаагийн “хичээл”-ийг сонирхон ажиглаж, бага сага задаргаа хийж үзэцгээе. Энэ нь хэдийгээр нэг л удаагийн, нэг л хэсэгхэн зүйл боловч бүхэл бүтэн үргэлжилсэн их амьдралын эгшин төдий зураглал гэж болно. Харин монгол нүүдэлчдийн амьдралд энэ мэт зүйл алхам бүр тохиолдох тул информал боловсролын “ээлжит хичээл” гэхээс аргагүй бөгөөд үүнийг албан боловсролын анги танхимын тогтолцоо дахь ээлжит хичээлтэй адилтган хутгаж болохгүй нь ойлгомжтой. “Монголын нууц товчоо”-нд буй хэн бүхний сайн мэдэх мэдээгээр, Добун мэргэн, Алан гоо эх хоёул Бэлгүнүдэй, Бүгүнүдэй гэх хоёр хөвүүнтэй атал Добун мэргэн үгүй болсны хойно, бэлэвсэн эх нь Бугу хатаги, Бугуту салжи, Бодончар мунхаг гэх гурван хөвүүнийг төрүүлжээ. Гэтэл Бэлгүнүдэй, Бүгүнүдэй хоёр хөвүүн нь: “энэ эх, гэрт гагц Маалига баягудайгаас өөр эр үгүй атал гурван хөвүүнийг төрүүлэв. Эд гурван хөвүүд түүнийх буй заа” хэмээлдэн эх юүгээн эчнээ далдуур хэлэлцэхийг, Алан гоо эх ухаж мэднэ. Түүнээс

8 Энд хүний болон газар усны нэр тэргүүтнийг Д.Цэрэнсодном нарын боловсруулсан “Монголын нууц товчоо”-ны сонгомол эхийг (Хөх Бичин жилийн) барьсан болно.

болж эхийн сэтгэл эмзэглэн зовиносон нь лавтай ба зөрүү ойлгоц авсан хөвүүд алсдаа хагаралдан тэмцэлдэхээс эмээж болгоомжилсон нь илт болой. Хэрхэн тэр аюулыг алгасарч гарах вэ? Ухаант эх ундууцан гомдоллохыг огоорч, ухааруулан сэнхрүүлэхийг чухалчлан сонгож, тэд хөвүүдийг сургаж боловсруулан оюун санааны нэгдмэл байдалд хүргэхийг зорьсон аж. Ийнхүү монгол нүүдэлчний информал боловсролын хэрэгцээ амьдрал дээрээс шууд урган гарч, нэг ёсондоо, сургалтын зорилгыг амьдрал аяндаа тавиад өгдөг байна. Эх сургалтыг үр дүнтэй болгохын тулд түүнээ хэрхэн явуулах тухай ихэд эргэцүүлэн үзсэн нь түүний хичээлээс харагдана. Бидний өдгөөгийн өндрөөс харахад сургалтын академик, прагматик хэлбэрийг хослуулж, бихевиор, конструктив хандлагыг зэрэгцүүлэн хэрэглэсэн гэж үзэхээр байна. Энэ нь орчин цагийн тэдгээр онол баримтлалууд угаас амьдралын үнэнийг илэрхийлж чадсан болохлоор цаг хугацаанаас шалтгаалахгүй, бас зохиомол бус болохыг нь давхар нотолж буй хэрэг юм.

Сүегэр үг өгүүлэх, сургаж суях-бас нэг ёс байжээ⁹. Дайн тулаанд мордуулах, хадамд гаргах, ертөнцийн жамаар өрх гэр толгойлон үлдэх тэргүүтэнд эцэг эх, ахмад настан, ард үлдэгсэд сүегэр үг өгүүлдэг байсан аж. Одоо цагт сургуульд явах, гадаад гүрэнд одох зэрэг том үйл хэрэг бүтээхээр зорчиход мөнөөх сүегэр үгийг өгүүлнэ. Энэ нь зүйрлэлд тулгуурлан ятган үнэмшүүлэх голлох ажээ. Алан гоо эх хөвүүдээ сум (мөс) үзүүлэн ятгасан нь суяхын жишээ болно. Адил төстэй үзэгдэл юмсын мөн чанарыг зэрэгцүүлэх метафорын аргыг ашиглаж байгаа нь тэр. Тэгэхлээр, суях нь монголчуудын хувьд сургалтын эртний арга байв. Ажлаа босон суун амжуулах байнгын хөдөлгөөнт нүүдэлчин монгол хүний сэтгэхүйд сүегэр үг хэлэх нь ихэд ойр дөт бөгөөд юмыг хүүхдэд түргэн үнэмшүүлэн ойлгуулах, бат нот үлдээх онцлогтой. Түүнээс гадна сүегэр үг нь дандаа эерэг сайн байх албагүй бөгөөд бас сөрөг талтай, зэм хүргэх тохиолдолд ч гарах ба үүнийг Ш.Гаадамба гуай “сүегэр үгийн дотор бас “чамалиар сүегэр дуулгах” буюу зэмлэл дуулгах өөр нэг төрөл зүйлс байжээ”¹⁰ хэмээн тэмдэглэсэн байна. Бас тэрийг хар, энийг үз гэхчилсэн харшилдуулан жишсэн байдлаар ч хэлэх ажээ.

Сүегэр үг ба чамалиар сүегэр өгүүлэх нь хэлэх гэсэн утга санааг бодтой зүйлд холбон,

үлгэр дууриал авахад чиглүүлнэ. Үүнийг бүр нарийвчлан эдүгэчилбэл сургалтад загварлахуйг хэрэглэсэнтэй ч дүйж мэдэхээр байна. Докторант Б.Мэндхүү “Хүний биеийн бүтэц зүй”-н хичээлийн мэдрэлийн эрхтэн тогтолцоо “Уураг тархины бүтэц” сэдвийг заахдаа монгол гэрийн бүтэцтэй харьцуулан загварчлах аргыг сургалтад хэрэглэсэн нь шинж тэмдгүүдийн хоорондын аналог оюун дүгнэлтийн чөлөөт холбоосыг ашигласан явдал юм”¹¹ гэж бичсэн нь манайд энэхүү загварчлах аргыг хэрэглэн буйн баримт болно. Сүегэр, суях үгийн нарийн утгыг тайлбар тольд *соё/х* гэдэг нь өршөөл, эрдмээр хөхүүлэн хөгжүүлэх; соён сургах, соён гийгүүлэх гэх бөгөөд нөгөө *сүеэ* нь ургамлын үндэс хөөж сая ургаж эхлэхийг¹² хэлдэг аж. Эндээс үзэхүл тэр үгсийн боловсролд хамаарах утга нь юмны уг мөн чанарыг гарган язгуураар нь хэлэхийг заах ба заан сургахуйн нэгэн зүйл арга мөн болохыг илтгэнэ.

Алан гоо эхийн сургаал үг мянга хол давсан жилийн тэртээгээс¹³ уламжилж эдүгээ үеийг хүрчээ. Эрдэмтэн Ш.Гаадамба¹⁴, Ц.Баасандорж¹⁵ нар Алан гоо эхийн домогт¹⁶ орчин цагийн сургалтын практикт хэрэглэж ирсэн хэд хэдэн зарчим тусгагдсаныг олж тэмдэглэсэн нь сайшаалтай юм. Бусдын үрийг төрүүлсэн гэх сэрдэгдлээр сэтгэлээн чилээж асан Алан гоо эх, эв түнжингүй хөвүүдээ сурган соёсон хичээлийн

11 Мэндхүү Б. “Хүний биеийн бүтэц зүй”-н хичээлийн технологид загварчлах аргыг хэрэглэх боломж” Боловсрол судлалын ухааны доктор (PhD) зэрэг горилсон бүтээл, Уб., 2014, 19 дэх тал.

12 Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”, нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж хянасан Ц.Шагдарсүрэн, Уб., 2013, 659, 683 дахь талууд.

13 Алан гоо эх бол Чингис хааны 11 дүгээр үеийн дээдэс болох Добун мэргэний эхнэр бөгөөд түүнийг Х зуунд амьдарч байсан бодит хүн гэж үздэг.

14 Гаадамба Ш. “Сурган хүмүүжүүлэх уламжлал “Нууц товчоо” – нд тусгагдсан нь” Монголын нууц товчооны судлалын зарим асуудал Уб., 1990, 205-212 дахь тал.

15 Баасандорж Ц. “Алан-гуа эхийн домог ардын сурган хүмүүжүүлэхүйн эх сурвалж болох нь” Лавай МУБИС-ийн боловсролын онол арга зүйн сэтгүүл, 2009, №4, 79-81 дэх тал.

16 Сонирхуулан тэмдэглэхэд, эл сэдвийн гарал үүслийн талаар судлаач эрдэмтэдийн дунд зөрүүтэй санал байдаг байна. Алан гоо эхийн домогтой төсөө бүхий домог 2000 илүү жилийн өмнө Герэгт зохиогдсон Эзопын шог үлгэрт байдаг ажээ. Гэтэл үүнийг баримтлан Герэгт зохиогдсон домог бүх Азид түгсэн гэх баримтлалыг сөргүүлэн, Ц.Дамдинсүрэн гуай бичихдээ: “Гэвч энэ домог заавал Грект үүсээд, бусад аймагт дэлгэрэх ёстой биш ээ. Бусад аймаг угсаатны дотор үүсээд, Грект бичигдэж Эзопын үлгэрт орсон байж болно. Анх бичигдсэн, анх зохиогдсон гэдэг бол хоёр өөр асуудал юм” гэж уг сэдвийн гарлын тухай маргааныг хагалан шулуутгасан байдаг. (“Монголын хуучин уран зохиолын товчоо” өгүүлэл, “Академич Цэндийн Дамдинсүрэн дурсгалын түүвэр”, Уб., 2008).

9 Гаадамба Ш. “Монголын нууц товчооны судлалын зарим асуудал” Уб., 1990, 206 дахь тал.

10 Мөн тэнд 202 дахь тал.

байдалд одоо анхаарал хандуулъя. Алан гоо эх, “Хаврын нэгэн өдөр хонины хуршмал мах чанаж, Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Бугу хатаги, Бугуту салжи, Бодончар мунхаг энэ таван хөвүүнээ зэрэгцүүлэн суулгаж, нэг нэг мөс (сум)-ийг “Хугалагтун” гэж өгөв. Нэг мөсийг амархан хугачиж орхив. Бас таван мөсийг хамт боож “Хугалагтун” гэж өгөв. Тавуул таваар багцлан боосон мөсийг хүн бүр авч, тойруулж оролдоод, хугалан ядав”¹⁷ хэмээн Нууц товчооноо өгүүлнэ. Энэ бол уг хичээлийн тухай түүхэн сурвалжид тэмдэглэсэн баримтын эхний хэсэг.

Эх, сургалтаа амжилттай болгохын тулд өдөр цаг, орчин нөхцөл, суралцагчийн сэтгэл зүйн бэлтгэлийг сайтар хангаж, тэднийг мотивацлах (сэдэлжүүлэх, сонирхлыг хөдөлгөх, анхаарлыг татах, идэвхжүүлэн өдөөх г.м.) хэрэгтэйг урьдаас ойж мэдсэн байна. Нүүдэлчин ахуйд өсөж бойжсон сэтгэхүйгээр бодвоос, Алан гоо эх орон гэрийг цэвэрлэн цэмцийлгэж, гэрийн гаднах, дотнох ажлыг бүрэн зохицуулж, завчилсны зэрэгцээ хүн амьтны хөл хөдөлгөөн татарсан үеийг сонгосон нь лавтай. Эхэд (текстэд) бичснээр “Хаврын нэг өдөр хонины хуршсан мах чанаж” гэдэг бол цаг үеэ гайхалтай сайн тохируулж буйн шинж. Нүүдэлч малчны хувьд жилийн дөрвөн улирлаас хаврын эхэн үе хамгийн хүнд тарчиг цаг байдаг юм. Дээрээс нь монгол нутгийн хавар цагийн хүйтэн салхи, улаан хавсаргыг яалтай билээ. Дулаан улиралд нөөцөлсөн бүх хоол хүнс, тэр дундаа махан хоол барагдаж, мал төллөөгүй тул сүү, цагаан идээтэй золгох ер болоогүй, хүйтний эрч тэгтлээ нугараагүй тул түүнийг давж гарах эрч хүч (энерги) хэрэгтэй хэвээр байдаг. Мал сүрэг ч ялгаагүй тун хүнд, биедээ нөөцөлсөн тарга хүчээ барж, хээл нь хүндэрсэн, өвсний шимт чанар хамгийн доод цэгтээ тулсан байх ажаам. Тийм учраас, хүнтэй, малтайгаа ихэд сульдаж ядарсан болохлоор хат хавраар харших хэмээн ярилцдаг билээ. Тийнхүү өлөн ээлмүүн, харшиж ядарсан цагаар хонины хуршсан мах чанана гэдэг зөвхөн үнэрийг нь авах төдийд л хүүхэд битгий хэл, хүүхдийн сэтгэл өөрийн эрхгүй татагдан хорхойсмуй. Алан гоо эх тэр өдөр лав үүцээ задалсан биз. Энэ бол монгол эх үр хүүхдээ шинэ зүйлд сургаж багшлахуйд хар туршлага, сэтгэлийн гүн мэдрэмжээр түүнд бэлтгэж буйн үлгэр болой. Үүгээр мөшгин бодвоос багшийн хичээлийн бэлтгэл зөвхөн түүгээр хязгаарлагдсангүй бөгөөд хэзээ, юуг, хэрхэн зааж сургах вэ гэдгийг урьдаас сайтар бодож, боловсруулан төлөвлөсний үр дүн нь орчныг тийнхүү гойд сайнаар бүрдүүлсэн

явдал юм. Хэрэв та анзаарсан бол сая би багш гэдэг үгийг хэрэглэв. Зааж сургасан нь мянга гаран жилийн хойно огт хуучраагүйгээр барахгүй та бид нар хүртэл өнөөдөр хичээлд нь задаргаа хийгээд ийнхүү сууж байх тэр хүнийг багш гэхгүй юм бол, өөр хэнийгээ ч багш гэх билээ, үнэндээ. Тэгээд ч, Алан гоо ба бусад эх хатад хамгийг оройлсон “тэнгэрийн хөвүүд” хаан эздийг сурган тэжээсэн гэгцгээх билээ, бид.

Алан гоо эхийн боловсруулсан ээлжит хичээлийн хөтөлбөрийн (curriculum) тойм агуулгыг эдүгчлэн сэргээе хэмээн оролдъя.

Хичээлийн зорилго нь: Эе эв эрхэм чухлыг ухааруулах

Агуулга нь: Энгийн сум (мөс) ашиглан нэг эетэн болж явахад сургах, тийм итгэл үнэмжил олгох үйлийг үйлдэх

Арга зүй нь: Тайлбарлан ярих

Үг хэрэглэн зэмлэх

Хамтран ажиллах

Кейс ашиглах (тодорхой жишээн дээр) гэх зэрэг

Онол баримтлал нь: хосолмол онол, хандлага (эклeктик)

Үнэлгээ нь: хүүхдийн ойлгоцоор үнэлэх арга

Хэрэглэгдэхүүн нь: мөс, мах ... гэхчлэн үргэлжлүүлэн бичиж болно.

Уг хичээлийн орчин бүрдүүлэхийг дээр өгүүлсэн. Одоо явцыг нь үзье. “Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Бугу хатаги, Бугуту салжи, Бодончар мунхаг энэ таван хөвүүнээ зэрэгцүүлэн суулгаж” гэсэн эхийн (текстийн) дараагийн хэсэг бол сургалтыг зохион байгуулахад хамаарна. Сургалтын явцыг олигтой удирдаж чадахгүй бол багш хичнээн бэлтгэж, хичээлийг оновчтой сайнаар төлөвлөөд ч гавьтай үр дүнд хүрэхгүй. Алан гоо эх угаас суралцагчийн зан үйлд нөлөөлөх хандлагыг¹⁸ барьсан нь эхнээс илт байв. Хөвүүдийг “зэрэгцүүлэн суулгаж” гэснээс үзэхүл, монгол гэрт тэрээр хөвүүдээ өөр рүүгээ хандуулан, хагас тойргоор суулгасан дүр зураг төсөөлөгдөнө. Ийм байрлал нь багш, суралцагчид нүүр нүүрээ харсан, багшаас суралцагчтай, суралцагчаас багштай адил тэгш харилцахад хамгийн тохиромжтой хэлбэр юм. Тэгээд ч, багш хичээлийн сэтгэл зүйн бэлтгэлийг машид сайн хангасан болохлоор тэдний хооронд бүлээн дулаан уур амьсгал тэрхэн дор бүрдэж, амьд идэвхтэй харилцаа үүссэн нь тодорхой.

Эхийн (текстийн) дараагийн хэсэгт “нэг нэг мөс (сум)-ийг “Хугалагтун” гэж өгөв. Нэг мөсийг

¹⁷ “Монголын нууц товчоо” сонгомол эх Уб., 11 дэх тал.

¹⁸ Хичээлийн зохион байгуулалтын эл хандлагыг “Багшлахуйн менежмент” Уб., 2013, нэмэн засварласан 2 дахь хэвлэлээс дэлгэрүүлэн харж болно.

амархан хугачиж орхив” гэжээ. Энд багш энгийн сумны мөн чанарыг ойлгуулах туршилт явуулсан байна. Өөрөөр хэлбэл, мөсийг нэг нэгээр хугачих автомат үйлдэл хийлгээд түүнээ янз бүр нөхцөлд туршсан нь сургалтын өнөө цагийн биевиор болон прагматик онолыг хослуулан хэрэглэснийг харуулна. Эхийн (текстийн) дараах хэсэгт “Бас таван мөсийг хамт боож “Хугалагтун” гэж өгөв. Тавуул таваар багцлан боосон мөсийг хүн бүр авч, тойруулж оролдоод, хугалан ядав” гэж буй. Энэ тохиолдолд сурахуйн дээрх онолуудыг хослуулан (эклeктик маягаар) хэрэглэсэн нь бүр ч ил тодорхой. Мөсийг нэг нэгээр өгсөн нөхцөлөө өөрчлөн, багцлан боож, суралцагчдаар туршуулав. Тэд багц сумыг хугалж эс дийлнэ. Хөвүүд тэгээд мөс ганцаар бол хялбар хугардаг, харин тэднийг багцалбаас эс хугардаг гэх мөсний мөн чанарыг ухаарцгаамуй. Багш жижгээс томруулах, томоос жижигрүүлэх замаар сэтгэж, үнэнийг танин мэддэг индукци ба дедукци аргыг хэрэглэсэн нь бас харагдаж байна. Тийнхүү нэгэн монгол эх энэ цагийн онолыг мэдэхгүй мөрт мэдээд, мэдэх төдийгүй хэрэглээд буйг юу ч гэлтэй билээ. “Ухамсаргүй хэрэглэх”, “хар ухаан” ч гэмээр ч юм шиг ...

Одоо хичээлийн оргил үе буюу тайлал хэсэг, зорилгоо гүйцэлдүүлэх хамгийн чухал хэсэгт шилжинэ. “Бас Алан гоо таван хөвүүддээ сургаал үг өгүүлрүүн: “Та таван хөвүүн миний ганц хэвлийгээс төрөв. Та нар саяны таван мөс мэт ганц ганцаар болбол, тэр нэжгээд мөс мэт хэнд ч хялбар дийлдэнэ. Тэр цугласан мөс мэт хамт нэгэн зетэн болбоос, та нар хэнд ч хялбар яахан дийлдэнэ хэмээв” гэх эхийн (текстийн) эл хэсгээс үзэхүл, мөнөөх өмнө хэрэглэсэн сургалтын аргуудыг улам дэлгэрүүлэн, агуулгыг шал өөр зүйлд хөрвүүлэн, оюун дүгнэлт болгон хувиргаж байна. “Мөс” хэмээгдэх нэгэн зүйл зэвсэг болсон бодитой эд зүйлийн мөн чанарын тухай ойлгыг хүмүүний амьдрал дахь эе эв гэх хийсвэр зүйлд рүү хувирган шилжүүлж, агуулгыг дэлгэрүүлэн хөгжүүлж¹⁹, хүүхэд бүр өөр өөрсдийн гараар туршин үйлдэж, тус тусын ухаан сэтгэхүйд эе эв гэх цоо шинэ ухагдахууныг бүтээцгээж байна. Үүнийг л хэрэв мэдлэг зохиомжлон бүтээх конструктив хандлага гэхгүй юм бол өөр бас юуг бид тэгж хэлэлтэй билээ. Алан гоо эхийн хичээлийг өнөөгийн олон чухал онол тухайлбал, консруктивизм (өөрөөр нь үйлдүүлсэн), экзистенциализм (эе эвийг сахих нь оршихуйн үндэс), Маслоугийн хэрэгцээний шатлалын онол, багаар ажиллах зарчим тэргүүтний алинтай ч холбон тайлбарлаж

болох тул өнөөгийн дэлхий дахиныг хамарсан сургалтын онолуудыг ямар нэг хэмжээгээр хамарсан мэт харагдаж, хүмүүний сурахуй гэгч нь үнэхээр нийтлэг шинжтэйг илтгэнэ.

Социалист нийгмийн үеэс л тоочсоор байсан цөөн хэдэн хүний хэлсэнчлэн болчихдог бус харин хүмүүний сурах, сургах, заах тэргүүтэн нь мөн чанарын хувьд аль эртнээс уламжлан ирсэн язгуур нэгтэй түгээмэл зүйл гэдгийг Алан гоо эхийн хичээл тийнхүү харуулсан мэт санагдана. Харин тэр хичээлийг манай судлаачид тал талаас ухан үзэж буйг угтан авууштай сайн хэрэг юм. Тухайлбал, эрдэмтэн Ц.Баасандорж хичээлийн технологи²⁰, магистр Д.Мөнхцэцэг менежмент талаас судлан үзсэн байна. Залуу судлаач Д.Мөнхцэцэг Алан гоо эхийн хичээлийн аргыг менежментийн төлөвлөлт, зохион байгуулалт, хошуучлал хяналт гэх функцүүдтэй холбон судалж сэргээн сануулах, утга санааг ойлгох, хэлэлцүүлэх, тодотгох, бататгах, дүгнэх гэсэн үе шаттайгаар 330 гаруй сурагчдыг оролцуулсан туршилт судалгааг амжилттай хийжээ²¹. Сургалтын технологи гэх ухагдахуун ямар нэг байдлаар дэс дараа, арга чаргыг илэрхийлсэн хуучин утгаа алдаж, мэдээлэл харилцааны технологийг сургалтад ашиглах шинэ агуулгыг илэрхийлэн буй ХХI зуунд ч Алан гоо эхийн хичээл ач холбогдлоо алдсангүй. Анги танхимын гэгдэх өнөө цагийн болон аль эртний Алан гоо эхийн хичээл хооронд алд дэлэм зөрөө байх боловч анзаарч үзүүштэй нэг зүйл байна. Тэр нь юу вэ гэвэл, Алан гоо эх “юу заах вэ?” гэсэн өөрийн үйлд бус, харин хүүхдүүд ”юунд сурах вэ?” гэсэн бусдын үйлд төвлөрснөөр ихэд ялгаатай юм. Саяхныг хүртэл манай багш нар хичээлд голлон анхаарч байсан бөгөөд харин одоо тэрхүү хандлагыг орхин суралцагчдаа төвлөрөхийг чармайн энэ талаар зарим амжилтад хүрч буй нь сайшаалтай хэрэг юм.

Мөн манай улсын сургалтын практикт дээр үеэс ихэд яригдах болсон дидактик нэгжийг томсгох тухай П.М.Эрдэниевийн онол гэгч зүйлийг эндээс бас хялбархан ажиглаж болно. Дидактик нэгжийг томсгох гэх ухагдахууныг манай судлаачид хэрхэн үзэж буйг Э.Болормаа, Р.Магсар, З.Баярмагнай нарын бүтээлээс харж болно. “Өөр хоорондоо ижил төстэй (төрөл) эсвэл эсрэг тэсрэг ялгаатай гэхээр онолын мэдлэг тэдгээрийг эзэмшихэд (бүтээхэд) тохирсон

20 Баасандорж Ц. “Нэгэн”үзүүлэх хичээл”-ийн тухай нэхэн эргэцүүлэхүй” Лавай МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2013, №11, 11-16 дахь тал.

21 Мөнхцэцэг Д. “Алан-гуа эхийн сургаалийн үзэл санааг дунд сургуулийн сургалтанд туршсан нь” Боловсролын удирдлагын магистрын дипломын ажил, МУБИС, Боловсролын удирдахуйн ухааны тэнхим, 2014.

19 Чухам үүнийг манай улсын багш нар бид дидактик нэгжийг томсгох хэмээн ярилцах бүлгээ.

ерөнхий арга барилыг дотоод гүний нэгдлийн үүднээс авч үзэж, иж бүрдэл болгон судлах үйл явц гэж ойлгож болно”²² гэсэн бол “Дидактик нэгжийг тогтолцооны шинжилгээний зарчмаар томсгоно гэдэг нь өөр хоорондоо ижил төстэй эсвэл эсрэг тэсрэг гэхээр салангид тусгаар мэт олон мэдлэгийг дотоод гүний нэгдлийн үүднээс танин барьж нэгтгэн, цаг хугацааны хийгээд орон зайн хувьд нэгдмэл байдлаар авч үзэж судлахыг хэлнэ”²³ гэжээ. “Зураг зурж сурахуйд, гурван зүйлийн зам буй, тэргүүнд; өөрийн сэтгэлээс төрөгдөж зурах, хоёрт; багшийг дагаж ёсоор зурах, гуравт; бодитойг барьж, адил зурах энэ гурваас эрхэм нь санаанаас төрөгдөж зурах нь маш эрхэм хэмээжүхүй”²⁴ хэмээн В.Инжаннаши абугай бичсэн нь хэдийгээр уран сайхны бүтээлч сэтгэхүйд хамаатуулан хэлсэн шууд утгатай боловч хүмүүний сэтгэн бодох үйлийг харуулсан сурахуйд халдаан үзэж болох нэгэн зүйл онол юм. Түүгээр бол Алан гоо эхийн хичээл аль ч талаар дээрх онолын гурав дахид нийцэх агаад информал боловсрол сургалтын сонгодог жишээ болно.

Алан гоо эхийн хичээл сургаал цааш цааш өртөөлсөн нь тодорхой. Үүнийг Өгэлүн эх хөвүүдээ хэрхэн сургасныг В.Инжаннаши их л урнаар сэтгэн өгүүлсэн байна. “Тайцзугийн ах дүү улам өсч, ав шувуунд баахан зөрчилдөн, шар шор хэмээн эвдрэлцсэнд Өгэлүн эх их зовниж, нэгэн өдөр хүүхдээ дуудан ирж, хамт зогсоогоод эцгийнх нь саадгаас таван сумыг сугалан авч, түүнийг та тавуул хамт барьж хугал хэмээн өгсөнд аль нь ч цөм хугалан эс чадвай. Төдий мэсийг (мөсийг) салгаж, нэг нэгээр хугалуулсанд цөм хугалбай. Өгэлүн эх хөвгүүнээ сурган өгүүлрүүн: ”Миний хүүхэд та үз, адил сум бөгөөтөл хамтадваас бөх болоод, хагацваас хэврэг болжухуй. Танай ах дүү тавуул мөн мэт болой, эдүгээ та эвтэй сайхан явбаас урьдын цугласан мэс мэт бусдад үл ялгуугдмуй, хэрвээ эвдрэлцэн салалцваас хожмын салсан мэс мэт гагц хүмүүнд ч чадагдмуй. Танай эцэг гагцаар явсаар эндэгдсэнийг үзэв үү. Үлдсэн та нар өрөөсөн бэлэвсэн эхийнхээ сэтгэлийг баахан амруулбаас зохимуй”²⁵ гэжээ. Энэ мэт сургалт, боловсролын монгол уламжлалыг хөндөж ярилцан бүхүйд “оюунтай төрсөн” Өгэлүн эхийг тийнхүү дурдалгүй өнгөрч яахан болох билээ. Есүхэй баатар Татаарт хорлогдоход Тэмүжин 9,

Жочи Хасар 7, Хачигун элчи 5, Тэмүгэ отчигин 3, Тэмүлэн өлгийтэй балчир нялх байцгаасан гэдэг. Өгэлүн эх тэднийг ганцаар сургаж тэжээсэн. Бас өөрийн тав дээр үрчилсэн дөрвийг²⁶ нэмж, тэднээ “суут хөвүүд”, “хаад”, “хуультан сайцуул” болгон өсгөхийн тулд:

”Өхийтөл богтолж, огдойтол бүсэлж,

Онон мөрний өөд уруу гүйж

Олирс, мойлс түүж

Өдөр шөнө хооллон тэжээв”²⁷ хэмээгдэх ажаамуй.

Өгэлүн эхийн сургах эрдэм, үлгэр дууриал нь ажиллаж амьдрах явцад сурдаг монгол өвийн тухай амьд баримт юм. Чингис хааныг, өөрийнх нь аугаа их суу билиг, тухайн үеийн түүхэн зайлшгүй мэтээр тайлбарлах боловч информал сургалт, гэрийн сургуулийн тус дэм, эхийн нөлөө, сургах эрдмээс ангид үзэж боломгүй мэт. Ш.Бира гуайн мэдээлснээр²⁸, тухайн үед амьдарч байсан Бар Хебрюс (Bar Hebraeus) хэмээгч бичгийн их хүн Эши буюу Сорхагтани хатныг Христийн шашныг ивээн тэтгэгч их хаан Константины хатан Хеленатай зүйрлэн ихэд магтан өргөмжилж, дөрвөн хүүгээ гойд сайн сургасан тухай өгүүлсэн байдаг нь төдий л их хэтрүүлэл бус байжээ. Эши хатан өөрийн хөвүүд Мөнх, Хүлэгү, Аригбөх, Хубилай нарын амьдрал үйлсэд хүчтэй нөлөөлсөн нь түүхийн баримт сэлтээс тодорхой байдаг.

Монгол ухаан далайд “тэжээхүй” хэмээх нэг ухагдахуун яван байх бүлгээ. Үүнийг эх, эцэг нь үр хүүхдээ шувууд ангаахайг хооллох лүгээ адил хялбар өнгөц үзэх боломжгүй мэт санагдана. Юу гэвэл, *тэжээх* гэх эл ухагдахуун хүмүүний хувьд зөвхөн хоолох төдий бус сургах, хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, нийгэмшүүлэх гэхчилсэн өргөн утга агуулга бүхий нийгэмшсэн ойлголт бололтой. Манай улсын боловсролын хүрээнд коммунист хүмүүжлийн онолыг албадан хэрэгжүүлсэнтэй сургалт, хүмүүжил гэх эл хоёр ухагдахууныг үзэл сурталжуулан заагласан үе бий. Ш.Шагдар гуай “Монгол хэлний хүмүүжил гэдэг үг нь “хүмүүн” гэдэг үгнээс үүссэн “хүмүүжил”, “хүмүүн болох”, “хүмүүнжүүлэх” гэх зэргээр үзсэн нь хүмүүний төрлийг нэгэнт олоод төрсний хойно “дахин хүн болгох” гээд ч байгаа мэт зарим талдаа ойлгомж муутай санагдана. Ш.Сүхээ гуай энэ талаар бичихдээ: “Таван томоохон хэлэнд²⁹ хүн,

22 Марсар Р. “Суралцагчдад математикийн боловсролын цогц чадамж төлөвшүүлэх шинэ арга зүй” (6 дугаар ангийн математикийн жишээн дээр), Уб., 2009, 30 дахь тал.

23 Болормаа Э. “Киррикулим тогтолцооны инвариант загварыг боловсролын хэрэгцээний онцлогт нийцүүлэн тусгайлах арга зүй” (Анагаахын хими боловсролын жишээн дээр), Уб., 2009, 52 дахь тал.

24 Инжаннаши В. “Хөх судар” тэргүүн дэвтэр Уб., 2009, 154 дэх тал.

25 Инжаннаши В. “Хөх судар” тэргүүн дэвтэр Уб., 2009, 104 дэх тал.

26 Удуйд мэргэдийн Хүчү, Тайчууд аймгийн Бэсүд Хөхөчү, Татаарын Шихихутуг, Жүрхүний Борохул нарыг Өгэлүн эхэд авч ирж өгөхөд эх “өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгоё” хэмээн гэртээ тэжээвэй гэж “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэн буй.

27 “Монголын нууц товчоо” сонгомол эх, 22 дахь тал

28 Ш.Бира “Чингис хаан бол дэлхийчлэлийн их эцэг мөн” Зууны мэдээ сонин 2012.12.7, №289,290

29 Орос, англи, герман, франц, испани хэлийг хэлжээ.

хүмүүжил гэсэн 2 үг цөм өөр язгууртай байна. Жишээ нь, орос хэлний “Воспитание” гэдэг үг нь “дахин тэжээх” тэтгэх гэсэн санаа даруй мөн болой”³⁰ гэжээ. Бас “Европ зүгийн улсууд, голдуу латин соёлын хүрээнээ буюу латин, грек соёлын хүрээнээ багтсан улс аваас, хуучин монгол, даруй нангиад, энэтхэгийн соёлын хүрээний улс байжээ”³¹ гэсэн Б.Ринчен гуайн дүгнэлтээс санаа авахад илүүдэх юун. Мөн сүүлчийн мэдээгээр манай Боловсролын хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан “Боловсролын философи” номд “Биеэ засаад гэрээ зас. Гэрээ засаад төрөө зас” гэсэн эртний сургаал дахь гурвалыг “Биеэ тэжээх ухаан”, “Гэрээ засах эрдэм”, “Төрөө төвшитгөх засаглал” хэмээн задлан тайлбарласан байна³².

Дээр өгүүлсэн мэдээг үзэхүл “тэжээх”, “тэжээж өсгөх” гэсэн хэллэг нь хооллох, харж хандах төдий дан ганц утга илэрхийлэхгүй хүмүүний сурах, сургахыг (өргөн утгаар, багшлах) хамтатгасан өргөн дэлгэр санаа агуулсан бололтой. Өнөө хэр нь “би чамайг тэжээж өсгөсөн” гэлцэх нь “би чамайг хооллож өсгөсөн” гэх утга яавч биш билээ. Чухамдаа, монголын их хаад, ноёдыг тэжээж өсгөсөн Алан гоо эх, Өгэлүн эх, Бөртгөлжин хатан, Сорхагтани бэхи, Мандухай сэцэн, Өндөр гэгээний эх Ханджамц тэргүүтэн хатад эхчүүдийг бид анхны багш нар хэмээн тооцох нь зүйд лав нийцэх биз ээ. Үүнд холбогдуулан тэмдэглэхэд, түүхэн иш баримтаас үзэхэд, хитан угсааны Елюй Чуцай, уйгур үсэгт нэвтэрсэн хэрэйдийн Хингай, ойрадын Ариун, бүх улсын их заргач татаарын Шигихутуг, Алтан ургийнханд үсэг бичиг заасан уйгурын хааны дүү Юлитөмөр, уйгурын Тататунга, Мөнх хааны багш ираны монголч эрдэмтэн Ибтихар-Эд-дин Мухамет³³, Юань гүрний үеийн Улсын багш Пагва³⁴ тэргүүтэн олон угсааны эрдэмтэн мэргэд ч ялгаагүй манай эртэн цагийн албан ёсны ууган багш нар мөн билээ. Монгол хэлэнд багш гэдэг үг өргөн утга санааг илэрхийлнэ. Албан ёсны багш нараас гадна аливаа сайн үйлийг зааж сургасан хүмүүнээ багш хэмээн хүндэтгэн дууддаг ёсон буйг энд бас дурдахгүй өнгөрч боломгүй.

Эрт дээр үеэс монгол нүүдэлчдийн дунд информал сургалтаас гадна хязгаарлагдмал боловч албан, албан бус сургалт явсаар байж. Манай ахмад үеийнхэн тэмдэглэхдээ, “Тэр цагт өдөр тутмын амьдралдаа хаан хөвгүүд, шадар ноёд, түшмэддээ төрийн ёсны арга ухаанаа аман сургаал маягаар сургаж өвлүүлдэг ёсон зонхилж байв. Чингисийн билиг сургаалыг Чингисийн зарлиг Их засгийн адил Чингисийн гэрээслэн захисан ёсоор жилийн эхэн, адагт хан хөвүүд, ноёд түшмэд хуран чуулж хичээнгүйлэн сонсож дагаж мөрдөх журамтай байжээ”³⁵. Энэ нь тэр цагийн сургалтын бас нэг хэлбэр бөгөөд эдүгчилбэл богино хугацааны сургалт (семинар, үзүүлэх ба сертификатын) болно. Ийм сургалт цааш үргэлжлэн Монголын Юань гүрний цагт тайцзу (Чингис) –ийн эрднийн сургаалыг мужийн эзэд ван нар их гэгээн харшид хуран чуулж сонсдог байсан тухай Юань улсын сударт тэмдэглэсэн ажээ. Мөн В.Инжаннаши XII зууны үеийн монголын амьдралыг бичихдээ “улсын доторхи сэцэн, сэргэлэн, эршсэн ардыг сонгож аймаг бүрт сургаалын буудал байгуулж, уйгур үсэг ба вэй – у үсгийг сургалгав. Төдий бичиг, цэргийн сургаал шалгалганд орсон гурван түм илүү нэр буй”³⁶ хэмээн тэмдэглэснийг үзэхэд тэр нэгэн цагт ч сургалт боловсролыг эрхэмлэн чухалчилж, албан ёсны сургуулийн газар байгуулан ажилуулж байсан байна. “Эзний дөрвөн хөвгүүн: Жочи, Цагаадай, Өгөдэй, Толуй. Эзний дүү Бэлгүдэй, Хасар хоёулын ахмад хөвгүүн: Ясубөх, Тожу. Жич эзний хүргэн Бутугийн ахмад хөвгүүн улсын зээ Нансар. Эзний төрлийн хүргэн Зэлмэ –ийн ахмад хөвгүүн Жибгэ Цэцэг ... Сүбэгээдэй баатрын хүү Рашаан. Гилүгэн баатрын дүү Тондой Чэрби. Жич жонон Мухулайн отгон дүү Бугу эдгээр эрдэнэ барилдаж, эршсэн нь гучин зургаан дүү нар хүүхдийг хамт бичиг цэргийн сургаалд оруулахаар мэдүүлсэнд Тайцзу зөвшөөн тогтоовой”³⁷ гэсэн нь ордны сургуулийн тухай баримт юм.

Монгол уламжлалт сургалт, боловсролын талаар Б.Ринчен, Ш.Гаадамба, Б.Жадамба, Ц.Баасандорж, Д.Баттогтох, Х.Дарамбазар, О.Дагвадорж, Ж.Лувсандорж, Д.Мишигдорж, Д.Наран, Х.Сампилдэндэв, Ш.Сүхээ, Х.Ховд-Абай, Ш.Шагдар, С.Шагдартовуу, Г.Эрдэнэ-Очир тэргүүтэй мэргэд чамгүй их судалгаа хийж, арвин баримт материал хуримтлуулжээ. Монгол сургалтын тогтолцоог эрдэмтэд цэгцтэй сайхан тайлбарласан байна. Б.Ринченгуай “хуучин монгол сургуультаан уг сургууль хийх хэлбичгээрээ гурван

30 Сүхээ Ш. “Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлал, дэвшлийн зарим асуудал”. - Уб. 1988, 8 дахь тал

31 Ринчен Б. “Монгол хэл” тэргүүн дэвтэр 29 дэх тал.

32 Н.Бэгз, О.Пүрэв, Г.Энхцогт, Д.Баттогтох, Б.Баярцэцэг, П.Мягмар, Ц.Лхагвасүрэн, П.Тунгалаг “Боловсролын философи” Уб., 2012, 278-284 дэх талууд.

33 “Монгол улсын соёлын түүх”, Уб., 1998, 332 дахь тал.

34 Хубилай 1260 онд их ор суусныхаа дараагаар Пагва ламтай тогтоосон харилцаагаа улам хөгжүүлэн бататгаж, 1264 онд түүнд “Улсын багш” (гүшри-хятадын Го- ши) цол хүртээв гэж академич Ш.Бира тэмдэглэжээ (Ш.Бира Түүвэр зохиолууд. -Уб., 2007, 69 дэх тал).

35 Нацагдорж Ш. Чингис хааны цадиг, Уб., 1991, 290 дэх тал.

36 Инжаннаши В. “Хөх судар” дэд дэвтэр, Уб., 2009, 281 дэх тал.

37 Мөн тэнд 468 дахь тал

зүйл байсан байнам. Түүний дотор хамгийн олон нь шарын шашны сургуультай байжээ. Монголын хуучин сургуультай хоёрдугаар хэсэг нь төрийн сургуультай байжээ. Олонх нь манж хэл бичигтэй, цөөвөр нь нанхиад бичиг үсэгтэй байжээ. Тооны хувьд шашны сургуультай хүмүүсээс цөөхөн боловч Манж дайчин улс, түүний дараах иргэн улсын харьяа өөртөө засах Монгол улсын үеэс төрийн алба хааж хошуу тамга, журган яам, аймаг чуулганы жасааны газар алба хаших хүмүүс байжээ. Хуучин сургуультай гутгаар хэсэг нь дан монгол бичгийн сургуультай³⁸ гэж манай боловсролын уламжлалт тогтолцоог тайлбарласан байна. Мөн Д.Баттогтох гуай “Боловсрол мэдлэг, мэргэжил олгох зорилготой 3 хэв шинжийн сургууль байжээ. Тухайлбал, үндэсний хэлбичгээр унших бичих, тоо бодох, зурах, урлах, бие махбодыг тамиржуулах, хүмүүжүүлэх зорилготой иргэний суурь боловсрол олгох гэрийн сургууль, төвд хэлбичиг зааж шашны суурь боловсрол эзэмшүүлэх буюу сүм хийдэд хурлын лам нарыг бэлтгэх шашны сургууль, хууль цааз, төр захиргааны боловсрол олгох буюу төрийн түшээ, тамгын ажилтанг бэлтгэх төрийн сургууль тус тус сургалт хүмүүжлийн ажлыг явуулж байжээ”³⁹ гэсэн байна. Ер нь манай уламжлалт боловсролын хүрээнд иргэний, шашин мөргөлийн, цэрэг армийн боловсролын өвөрмөц хослол үйлчилж байжээ. “Монголчууд эр цэргийн дансанд орох 15 наснаас 60 нас хүртэл цэрэг байж, “насан турш” байлдааны байнгын дадлага бэлтгэлтэй, дайнд мордоход тусгайлан сургуулилах шаардлага байсангүй, дохио өгөхөд ухасхийн босох арми ямагт бэлэн байжээ”⁴⁰. Энэхүү армийн бэлтгэл сургуулилтын сургалтын агуулга, арга хэрэглэгдэхүүн, зохион байгуулалт нь өнөө цагт ид яригдан буй “насан туршийн боловсрол”, “тасралтгүй боловсрол” гэх үзэлтийн өвөг үүсвэр ч гэмээр, ялангуяа албан ба албан бус боловсролын эртний нэгэн хувилбар байж болох юм.

Д.Наран гуай хятад түүхэн сурвалжийг судлан, Монголын төр ёсны боловсролын талаар чухал мэдээ сурвалжийг өгүүлсэн байна. Өгөдэй хаан нь хаан хөвгүүд, хишигтэн ноёд, дээдэс язгууртны хөвгүүдийг сургах албан ёсны сургууль байгуулсан тодорхой мэдээ байгаа аж. Алтан улсын нийслэл асан “Яньжин хотноо урьд нь Алтан улсын Нууц бичгийн яам байсан газар

Их Монгол улсын Улсын хөвүүдийн сургуулийг (1233 онд) байгуулан анхны монгол 18 сурагчийг тийш илгээн суралцуулсан”⁴¹ ажээ. Энэ бол монголд албан ёсны боловсрол эртэн цагаас үүсэн хөгжсөнийг нотолно. Өгөдэй хааны байгуулсан Их Монгол улсын хөвүүдийн сургууль нь Юань гүрний үеийн төрийн албан хаагч бэлтгэх бусад сургуулийн үндэс суурь болов. Мөн Юань гүрний үед үйлдсэн сүмийн чулуун хөшөө бичиг одоогийн БНХАУ –ын зарим газар хадгалагдан үлджээ. Шандү хотын Күнзийн сүм дэх чулуун хөшөөний бичээсийг Д.Наран гуай “Өгөдэй хаан “бичээч” болгохоор шилж авсан арван найман хөвгүүдийг хятад хэл сургах, хятад түшмэдийн хөвгүүд дүү нарыг гүрний хэл⁴², нум сум харвах ухаанд сургахаар дөрвөн анги болгон хувааж”⁴³ гэхчлэн орчуулжээ. Монгол хүүхдүүдийг монгол хэл бичиг, нум сум харвах ухаанд сургах талаар энд дурдаагүй нь тийм сургуулилтыг нутагтаа хийдэг бас өөр сургууль байсан байж болохыг ч үгүйсгэхгүй байна. Олон арван улс гүрнийг захиргаандаа оруулсан Их Монгол улс оршин тогтнохдоо тухайн үедээ ихэд боловсронгуй төр ёсны элит боловсролын тогтолцоог тийнхүү үүсгэн хөгжүүлж байжээ.

Дээр өгүүлсэн иш баримтыг үндэслэвэл манай хожуу үеийн боловсролын уламжлалт тогтолцоонд гэрийн⁴⁴, төрийн⁴⁵, шашны⁴⁶ гэсэн лавтайяа гурван гол хэлбэр байна. Эдгээр сургуулилтыг орчин цагийн боловсролын онол баримтлалаар үзвэл информал, албан ба албан бус боловсролын аль аль бүрэлдүүлбэр ямар нэг хэмжээгээр байсан нь харагдана. Шашны болон төрийн сургуулилтын хэлбэрт албан боловсролын хандлага түлхүү байхад ордны болон гэрийн сургуулилтад үйлийн явцад олох болон албан бус хандлага давамгайлах жишээтэй. Тэдгээр дундаас гэрийн сургуулилтын хүрээнд багтах информал боловсрол, тухайлбал, үйлийн явцад сурахуй, шавилан сурахуйн хэсэг манай сэдэвт илүү хамаарах болно. Өөрөөр хэлбэл, энэ нь цаг уурын хатуу ширүүн нөхцөлд, таван хошуу малыг адуулан аж төрөх нь их хүч чадал, арга ухаан, хатуужил, тэсвэр зориг самбаа шаардсан хүнд ажил учраас хамтын хүч зүтгэлээр үр хүүхдээ хар бага наснаас аж ахуй эрхлэн

41 Наран Д. “Монголын төр ёсны боловсролын түүх” (XIII-XIV зуун), Уб., 2001, 37 дахь тал.

42 Монгол хэлийг хэлсэн ажээ.

43 Наран Д. “Монголын төр ёсны боловсролын түүх” (XIII-XIV зуун), Уб., 2001, 56 дахь тал.

44 Зарим судлаач үүнд ордны сургуулийг хамруулсан байдаг.

45 Үүнд цэргийн сургуулилт лав хамаарах биз ээ.

46 Дагвадорж О. “Уламжлалт боловсролын тогтолцоонд монгол дацангийн гүйцэтгэсэн үүрэг”, Уб., 2004 зэрэг номоос дэлгэрүүлэн үзэж болно.

38 Ринчен Б. “Монгол бичгийн хэлний зүй”, тэргүүн боть.- Уб., 1964, 29-30 дахь тал.

39 Баттогтох Д. “Уламжлалт сурган хүмүүжлийн лекцүүд”. - Уб. 2008, 27 дахь тал.

40 Шагдар Х. “Монголчуудын аян дайны цэргийн урлаг” (XIII зуун), Уб., 2012, 356 дахь тал.

хөтлөх арга ухаанд сургаж түгээмэл мэдлэг, дадлага, туршлага олгодог боловсролын тэр хэсэг гэдгийг өмнө дэлгэрэнгүй өгүүлсэн болно. Гэрийн сургуулийн нөгөө нэг түгээмэл бус хэлбэр нь уран санаа, ухаан бодол, авьяас чадвар, ур дүй, нарийн багаж төхөөрөмж шаардсан дархан, мужаан, анагаах ухаан, урлаг, уран сайхны чиглэл юм. Үүнийг нарийн мэргэжлийн хүмүүс эрхлэн явуулна. Ийм гэрийн сургуулийг тухайн мэргэжлийг төгс эзэмшсэн хүмүүс эрхлэх бөгөөд тэд үр хүүхдэдээ юм уу, эсвэл авьяас, сонирхол бүхий бусад айлын ганц хоёр хүүхдийг гэрээрээ заан сургадаг байжээ⁴⁷.

Түүхэн баримтаас харахад Тайчуудын ноён Таргудай хирилтуг хэлэхдээ: “Тэмүжинийг бяцхан байх цагт авчирч сургаваас сурах төлөвтэй буюу хэмээн, эмнэг үрээ даага сургах мэт сурган соён явлаа. Одоо түүний ой нь орж, сэтгэл нь сэнхэрч амуу хэмээгдмүү.”⁴⁸ гэсэн байх ажаамуй. Чингис хаан дээд тэнгэрээс заяат язгууртан хүн болохлоор, Таргудайн хэлснээр тэдний ойг нь ортол, сэтгэлийг нь сэнхэртэл сургадаг сургалтын арга хэлбэр байсны баримт бөгөөд угаас ертөнцийн талыг эзэгнэхэд хүрсэн Чингис хаан түүний шадар түшиг хүчин цөм тэрхүү сургалтын буулгыг дамжин⁴⁹ бойжсон бизээ. “Олонхи эрдэмтний саналд үндэслэвэл, монголчууд үсэг бичигтэй болсон нь Чингис хааны үе болно. “Юань улсын судрын” 124 дүгээр боть, “Тататунгагийн намтар” тэмдэглэснийг үндэс болговол, хүчирхэг дайсан Наймааныг 1204 оны хавар “Наху хунд” дийлсэн Чингис хаан найманы эзэн Таян хаанд үйлчилж агсан дээд түшмэл Тататунгаг олзолжээ. Тэрээр, Таян хааны доор алтан тамгыг атгаж, эд агуурсыг хамаарах сайд байжээ. Чингис хаан тамгыг үзээд, юу болохыг асууж, уйгур үсэг гэгч байгааг мэдээд, тэрхүү уйгур үсгийг өөрөө сурч, алтан ургийн хөвгүүдэд сургаж, монгол хэлийг тэмдэглэжээ. Монголчууд тэр үеэс бичиг үсэг хэрэглэсэн байна”⁵⁰ Нэлээд баттай эх сурвалжаас авсан Ш.Озава авхайн эл мэдээ нь бичиг үсэг улмаар боловсролын талаар Их хаан хэрхэн анхаарч байсны баримт юм. Заримдаа Чингис хааныг бичиг үсэгт тайлагдаагүй байсан гэж бичсэн нь мэр сэр харагддаг ба тийм явган сул яриа ч нэлээн байдаг. Харин Озава авхайн эл

баримт түүнийг няцааж байгаа бөгөөд тэр зэргийн ухаан сийрэг, овсгоо самбаатай эрхэм хүн бичигт үсэгт тайлагдаагүй байх учиргүйн дээр бичиг үсэг байсан л бол түүнд суралцсан байх нь гарцаагүй юм.

Дээр иш татсан Таргудайн Хирилтугийн шазуур зуун хэлсэн үгэнд өөр нэг санаа цухас илэрч буй нь тэрээр хэдийгээр Тэмүжинийг хар багаас нь дайсагнан үзэж асан боловч өөрийн эрхгүй түүний сурган соёход оролцсон нь айл хотлоор нийлж үр хүүхдээ сурган бойжуулдгийн нэг баримт юм. Монголчуудын нүүдлийн зохион байгуулалтын онцлог тэдний сургалтын хэлбэрт нөлөөлнө. Тэд голчлон айл хотлоор хамтран аж төрнө. Айлсан саахалт бууж бараа бараандаа явж тус тусын аж амьдралыг харилцан дэмжихээр ойролцоо нутаглана. Энэ нь багш, шавийн холбогдох, шавь нь багштайгаа айл, саахалт бууж эрдэм ном заалгахад дөхөмтэй болдог байна. Түүнчлэн нүүдлийн зохион байгуулалтын хэлбэр түүний хувирамтгай шинж чанараас болж тухайн нэг хүүхэд боловсрол сургалтын олон хэлбэрээс бололцоотойг сонгон хэрэглэдэг байжээ. Хожуу үеийн боловч, өв уламжлалыг тодруулах үүднээс энгийн нэгэн бодтой жишээ татъя. Эрдэнэ мэргэн бандид, ханчин хамбо С.Жамъянгарав⁵¹ (1861-1917) үндэснийхээ тухайн үеийн боловсролын үйлчилгээг албан, албан бус, аж төрөх явцдаа олох информал аль аль хэлбэрээр хүлээн авч Буддын шашны сонгодог боловсролыг олж бас түүнийг бүтээлцэж явсан нь түүний намтраас⁵² тодорхой харагддаг.

Энд чухалчлан тэмдэглүүштэй нь манай уламжлалт сургалтын зарчмаар бол хүүхэд эхлээд өөрийн гэр, хот айл, саахалт айлаас эхлэн эрдэм боловсрол ахих хэрээр цаашлан явж сурах зайн хэмжээ нэмэгддэг байсан бололтой байдаг. Ханчин хамбо С.Жамъянгаравын хувьд өөрийн Асаатын хүрээний⁵³ тойргоос гарч суралцсан зарим гол гол хүрээ хийд, дацан сургуулийн зайг өдгөөгийн Архангай аймгийн газрын зураг дээр баримжаалан гаргавал ойролцоогоор 30 - 2500 км зайд орших

51 Жамъянгарав С. “Цаглахуй санааны найлзуур мод” зохист аялгууны жишээ шүлгүүд, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн Д.Цэндэхүү, Уб., 2011.

52 Цансрайгавийлодой (Зундуйсодов) “Төгс цогт дээд лам гэтэлгэгч чухаг хувилгаан эрдэнэ бандида ханчин Жамъянгарав Гэгээнтний намтрыг товчийн төдий өгүүлсэн хувьд төгөлдөр эгээрэл хангагч галбарвасан модон хэмээх оршиг” Төвөд хэлнээс орчуулсан Д.Ганболд, “Бат сүзэгт бандида хамба Жамъянгарав”, намтар сэлтийн орчуулга ба судлалын бүтээлийн эмхтгэл, судлалын боть – I, Уб., 2013, 10-54 дэх талд.

53 “Асаатын хүрээг гэх монголчуудын барьсан модон дугантай, уул ус хавчсан бяцхан хийд, 300 –аад бурсан хуврагтай, цогчин, чойр, мингүгын дугантай, баруун зүүн хоёр дацантай...” (Л.Хүрэлбаатар “Огторгуйн цагаан гарди” Уб., 1996, 244 дэх тал.) Эл хүрээг С.Жамъянгарав гэгээн өөрөө үүсгэн байгуулсан гэдэг.

47 “Монголын соёлын түүх” -Уб., 1998, 328 дахь тал.

48 “Монголын нууц товчоо” сонгомол эх, 59 дэх тал.


49 Буулга нь үхэр тэргэнд хөллөх нэг гол хэрэгсэл. Тэрэгний үхрийн хүзүүн дээр дарж гол зүтгэх хүч буулган дээр бууна. Буулга дамжих гэсэн хэллэг нь эр үхэр бүхэн буулган дор зүтгэдэг хувь тавилантай болохоор ямар нэг зүйлийг тойрохгүй дайран гарна гэсэн санааг илэрхийлж буй хэрэг.

50 Озава Ш. “Монголын нууц товчооны ертөнц” орчуулсан Б.Баярмэнд, Уб., 2002, 33 дахь тал.

хэд хэдэн бүс, тойрог болгож болмоор байдаг. Үүнд барагцаалбал 30 км зайд буюу нэг өртөө газрыг хамарсан эхний бүс нь айл, саахалт, нэг гол гэгдэх тэр хавьдаа томд тооцогддог нэгэн голын урсгал дагуу түүнчлэн уул даваагаар зааглагдсан зэргэлдээ орших өөр нэг голын нутагт очиж эрдэм сурах орон зайн хязгаарыг заана. Хоёрдох бүс нь 30 –аас 100 км орчим тойргийг хамарч, зэргэлдээ нутгийн хийд дацан юм уу, сайн багшид очиж тодорхой ухаанд мэргэших маягаар сурах хязгаар нутаг, дараагийнх нь 100 – 300 км хүрээ бүхий бүс нутгийн шинжтэй эрдэм сургалтын төвд хүрч нарийн мэргэших, түүний дараагийнх нь 300 км – аас цааш явж, ихэвчлэн богино хугацааны сургалт, санал бодлоо солилцох, ном хаялцах, зэрэг дэв ахих мэт дээд шатны сургалт байх жишээтэй хязгаар бүс, тойргууд байсан бололтой (9 дүгээр зургийг харна уу). Энэ болбоос суралцагч уугуул нутагтаа байнга оршин суусаар эрдэм сурах тухайд баримжаалан санаа гаргаж буй бөгөөд заримдаа бүр бага балчир наснаас хол газар сууж эрдэмд суралцсан тохиолдол ч цөөнгүй байх аж.

Зарим хүмүүс суурин иргэншлийн өндөр хөгжилтэй улс орнууд хүүхдэд тун бага наснаас гүн ухаан, хэл, тоо бодлого мэтийг зааж сургадаг бол манай улсад тийм явдал байгаагүй гэлцэнэ. Зохиогчийн хувьд хараахан тэгэж бодохгүй байна⁵⁴. Чухамдаа тэр мэт төөрөгдөл нь Ардын хувьсгалаас хойш соёл, боловсрол манай улсад хөгжсөн гэх суртал нэвтрүүлгээс болсон бизээ. Монголчуудын зүйр, цэцэн үгийн далай, оньсого, үлгэр, түргэн хэллэг, дайралцаан тэргүүтэнг хүүхэд ухаан суусан цагаас өдөр дутмын хэрэгцээ болгон амьдралын явцад суралцаж эхэлдэг. Тэдгээр ардын аман зохиолд философи, логик, арифметик зэрэг орчин цагийн шинжлэх ухааны эх ундрага цөм буй. Мэдлэгээс гадна чадвар олохыг чухалчлан үзэж сурахуйн чиг баримжаа болгож байжээ. Сүрэг хонийг гэхэд хүүхдээр хэдэн янз тоолуулж сургана.

9 дүгээр зураг. Уламжлалт Монголын сурахуйн зай тойргийн байдал



Эхлээд хэвтэрт нь тоолох, дараа нь хотонд нь нэг бүрчлэн хүзүүдэн тоолох, дараа нь гүйдэл дунд дараалан тоолох, дараа нь бэлчээрт нь багцаалан тоолох, эцэст нь өндөрлөг газраас бүхэлтгэн баримжаалж тоолох гэх мэт тоо тоолох аргад нарийн дэс дараатай суралцана. Зөвхөн тоо тоолох төдийгүй дараа нь нэмэх, хасах, хуваах, үржүүлэх үйлдлийг цээжээр хийх түүнчлэн гараа тоолох, чулуу өвөртлөх, модонд хигээс тавих, дээс зангидах, эрхи таслах, сампин цохих, бичиж бодох аргуудыг эзэмшүүлнэ. Энэ мэтийг тоочин дурдвал үнэндээ их.

Энэ бүх элдэв олныг тоочин нуршиж уншигч түмнээ баахан чилээсэн нь зохиогч миний хувьд сургууль боловсролын үүх түүхийг дурдан хайлах гэсэнд бус Чингисийн монголчууд тэр нэгэн цагт хэрхэн хүчирхэгжиж, хэнд ч эс дийлдэхээргүй болсны нэг гол сурвалж нь тэдний үл анзаарагдам хэрнээ үлэмж чухаг боловсрол сургалтын тогтолцоонд нь байсан биш үү гэх мөхөс нэгэн санаа сэдэхийг оролдсон хэрэг юм. Тэрхүү чухалчлан буй боловсролын тогтолцоо нь иргэдэд орчин цагийнх шиг шинжлэх ухааны академик мэдлэгийг танин мэдэхүйн (эпистемологи) аргаар сургаж боловсруулахгүй боловч тухайн нийгмийнхээ хэрэгцээнд яв зав нийцсэн амьдрахуйн, аж төрөхүйн, өөрийг хамгаалахуйн, товчдоо оршихуйн арга ухаанд сурган соёж байжээ. Монгол нүүдэлчин буюу нүүдэлч малчны амьдралын хатуу хүтүүг давах чадвар, ажлын эв дүй, байгаль цаг уурын хүнд нөхцөлийг туулах эр зориг, эрч хүч, ухаан самбаа, нугаршгүй их тэсвэр тэвчээр, хүмүүнлэг чанар нь хэнд ч эс дийлдэхүйн нууц увидас болж байсан ч билүү гэх сөөлжүүд гажууд бодолд автнам. Хэрэв зээ, үүнд үнэмшмээргүй байх аваас цасан бүрхүүл гилтэгнэх идэр есийн хасах 30-40 хэм хүйтэнд хөдөөгийн монгол малчныхаар айлчлан хэд гурав ч хамаагүй хонууд өнжүүд саатан үзэгтүн. Тэгээд найман зуу гаруй жилийн өмнөхийг төсөөлөн санахыг хичээвээс танд эрх биш нэг зүйл бодогдон, санагдан, эргэлзэх юуны магад билээ.

54 Үүнд холбогдуулан нэг мэдээ дуулгахад, дэлхийн 113 орны иргэдийн оюуны чадамжийг судалсан Баруун орны мэргэжлийн зарим эрдэмтэдийн хамгийн сүүлд гаргасан үнэлгээгээр нэгдүгээрт 108 оноогоор Сингапур, хоёрдугаарт 106 оноогоор Өмнөд Солонгос, гуравдугаарт 105 оноогоор Япон, дөрөвдүгээрт 102 оноогоор Итали, тавдугаарт 101 оноогоор Монгол, Ирланд улс IQ –гээр зэрэгцэн жагссан ажээ (Зууны мэдээ сонин, 2013 оны 3 дугаар сар 5, №52(4367)).

Гэхдээ тэр бүхнийг дэмий нэг үзээд өнгөрөх бус тэрхүү эгэл хялбар атлаа гайхамшигт зохицол бүхий сурахуйн арга ухаан, өв уламжлалыг энэ цагийн шинжлэх ухаан, технологийн эрч хүчинд зохистойгоор нийцүүлэн хэрэглэх аваас үр хойчоо сурган соёход үлэмж хэрэгтэйг монголчууд бид цөм яавчиг үл мартмуй зээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Дүгэр, Х. (2001). “Монгол улсад албан бус боловсролын тогтолцоо бүрэлдүүлэн төлөвшүүлэх онол, аргазүйн асуудалд, х.34. Улаанбаатар
- Даваасүрэн, Б. (1979). *БНМАУ-ын ерөнхий боловсрол түүний хөгжлийн хэтийн төлөв. Улаанбаатар*
- Жамъянжав, Т. (1987). *Ардын боловсролын системийг боловсронгуй болгох талаар МАХН-аас явуулсан бодлого. Улаанбаатар*
- Машлай, Т. (1958). *Монголын ерөнхий боловсролын хөгжилт. Улаанбаатар*
- Шагдарсүрэн, Л. (1976). *БНМАУ-ын ерөнхий боловсрол, хөдөлмөр политехник сургуулийн үүсэл хөгжилт. Улаанбаатар*
- Шагдар, Ш. (2000). *Монгол улсын боловсролын түүхэн товчоон, х.10. Улаанбаатар*
- Пүрэвдорж, Ч.(2011). *Багшлахуйн менежмент, х.134. Улаанбаатар*
- Пүрэвдорж, Ч. (2009). *Боловсролын хөгжлийн загвар, үечлэлийг тогтолцооны онолын үүднээс шинжлэх нэгэн боломж. Лавай МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, №4, х.21-27. Улаанбаатар*
- Пүрэвдорж, Ч. (2013). *Чингис хааны удирдахуй дагуулахуй (Чоно менежмент)” Улаанбаатар*
- Дээрхийн гэгээнтэн XIV далай лам Данзанжамц. (2013). *Эгэл атом дахь орчлон ертөнц (Манай дэлхийн төлөө шинжлэх ухаан ба шаашин ажиллах нь), х.3, 9. Улаанбаатар*
- Гаадамба, Ш. (1990). *Монголын нууц товчооны судлалын зарим асуудал, х.206. Улаанбаатар*
- Мэндхүү, Б. “Хүний биеийн бүтэц зүй”-н хичээлийн технологид загварчлах аргыг хэрэглэх боломж. *Боловсрол судлалын ухааны доктор (PhD) зэрэг горилсон бүтээл, х. 19. Улаанбаатар*
- Цэвэл, Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. Хоёрдугаар хэвлэл. Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж хянасан Ц.Шагдарсүрэн, х.659, 683. Улаанбаатар
- Гаадамба, Ш. (1990). *Сурган хүмүүжүүлэх уламжлал “Нууц товчоо”-нд тусгагдсан нь”. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал, х.205-212. Улаанбаатар*
- Баасандорж Ц. (2009). “Алан-гуа эхийн домог ардын сурган хүмүүжүүлэхзүйн эх сурвалж болох нь” *Лавай, №4, х.79-81. Улаанбаатар*
- Дамдинсүрэн, Ц. (2008). Монголын хуучин уран зохиолын товчоо. *Дурсгалын түүвэр. Улаанбаатар*
- Дамдинсүрэн, Ц. (1990). “Монголын нууц товчоо” сонгомол эх, 11 дэх тал. Улаанбаатар
- Баасандорж, Ц. (2013). “Нэгэн”үзүүлэх хичээл”-ийн тухай нэхэн эргэцүүлэхүй”. *Лавай, №11, х.11-16. Улаанбаатар*
- Мөнхцэцэг, Д. (2014). Алан-гуа эхийн сургаалийн үзэл санааг дунд сургуулийн сургалтанд туршсан нь *Боловсролын удирдлагын магистрын дипломын ажил. Улаанбаатар*
- Магсар, Р. (2009). “*Суралцагчдад математикийн боловсролын цогц чадамж төлөвшүүлэх шинэ арга зүй*” (6 дугаар ангийн математикийн жишээн дээр), х.30 Улаанбаатар
- Болормаа, Э. (2009). “*Кирикюлим тогтолцооны инвариант загварыг боловсролын хэрэгцээний онцлогт нийцүүлэн тусгайлах арга зүй*” (Анагаахын хими боловсролын жишээн дээр), х. 52. Улаанбаатар Инжаннаши, В. (2009). *Хөх судар. тэргүүн дэвтэр, х.154, 104. Улаанбаатар*
- Дамдинсүрэн, Ц. (1990). “Монголын нууц товчоо” сонгомол эх, 22, 59 дахь тал. Улаанбаатар
- Бира, Ш. (2012.12.7) “Чингис хаан бол дэлхийчлэлийн их эцэг мөн” *Зууны мэдээ сонин, №289, х.290. Улаанбаатар*
- Сүхээ, Ш. (1988). Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлал, дэвшлийн зарим асуудал, х.8. Улаанбаатар
- Ринчен, Б. “Монгол хэл” тэргүүн дэвтэр 29 дэх тал.
- Бэгз, Н., Пүрэв, О., Энхцогт, Г., Баттогтох, Д., Баярцэцэг, Б., Мягмар, П., Лхагвасүрэн, Ц, Тунгалаг, П. (2012). *Боловсролын философи. х.278-284 Улаанбаатар*
- “Монгол улсын соёлын түүх”, Уб., 1998, 328, 332 дахь тал. Бира, Ш. (2007). *Түүвэр зохиолууд, 69. Улаанбаатар*
- Нацагдорж, Ш. (1991). *Чингис хааны цадиг, х. 290 Улаанбаатар*

- Инжаннаши, В. (2009). *“Хөх судар”* дэд дэвтэр, 281, 468. Улаанбаатар
- Ринчен, Б. (1964). *“Монгол бичгийн хэлний зүй”*, тэргүүн боть, 29-30. Улаанбаатар
- Баттогтох, Д. (2008). *Уламжлалт сурган хүмүүжлийн лекцүүд*, 207. Улаанбаатар
- Шагдар, Х. (2012). *“Монголчуудын аян дайны цэргийн урлаг”* (ХIII зуун), х.356. Улаанбаатар
- Наран, Д. (2001). *“Монголын төр ёсны боловсролын түүх”* (ХIII-XIV зуун), х.37, 56. Улаанбаатар
- Дагвадорж, О. (2004). *Уламжлалт боловсролын тогтолцоонд монгол дацангийн гүйцэтгэсэн үүрэг*. Улаанбаатар
- Озава, Ш. (2002). *Монголын нууц товчооны ертөнц*. орчуулсан Б.Баярмэнд, х.33. Улаанбаатар
- Жамъянгара, С. (2011). *“Цаглахуй санааны найлзуур мод”* зохист аялгууны жишээ шүлгүүд, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн Д.Цэндээхүү, Улаанбаатар
- Цансрайгавийлодой (Зундуйсодов). (2013). *Төгс цогт дээд лам гэтэлгэгч чухаг хувилгаан эрдэнэ бандида ханчин Жамъянгара Гэгээнтний намтрыг товчийн төдий өгүүлсэн хувьд төгөлдөр эгээрэл хангагч галбарвасан модон хэмээх оршив*. Төвөд хэлнээс орчуулсан Д.Ганболд, “Бат сүзэгт бандида хамба Жамъянгара”, намтар сэлтийн орчуулга ба судлалын бүтээлийн эмхтгэл, судлалын боть, х.10-54. Улаанбаатар
- Хүрэлбаатар, Л. (1996). *Огторгуйн цагаан гарди*, 244. Улаанбаатар